



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г Санхүүгийн болон үйл ажиллагааны Г

тайлан батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1.9 дэхь заалт, “МОНГОЛ ШИЛТГЭЭН” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2017 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулсаныг дурьдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/



МОНГОЛ ШИЛТГЭЭН ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Г Компанийн ТУЗ-ийн гишүүдийг Г

сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, дахь заалт болон “МОНГОЛ ШИЛТГЭЭН” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийнхурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Ч.Амарбаатар
2. Д.Давгадорж
3. Л.Ариунболд
4. Г.Ганчимэг
5. Д.Ганболд
6. М.Ган-Эрдэнэ

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. П.Мөнхчулуун
2. Г.Мөнхбилэг
3. М.Отгонбаатар

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



/Ч.АМАРБААТАР/



“МОНГОЛ ШИЛТГЭЭН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г Компанийн цаашидын үйл ажиллагааны тухай Г

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1.9 дэхь заалт, “МОНГОЛ ШИЛТГЭЭН” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааг сайжруулж ашиг орлогыг нэмэгдүүлэх үүднээс доорхи ажилуудыг хийж гүйцэгхийг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Амарбаатарт даалгасгай.

Үүнд:

- Компанийн хөгжлийн концепцийг хөгжлийн шинэ эрин үетэй нийцүүлэн боловсруулах
- Компанийн үйл ажиллагааг жилийн 4 улирал болгох
- Усан парк байгуулах зураг төслийг боловсруулах
- 8 нэрийн дэлгүүрийг ашиглалтанд оруулах
- Шоу арга хэмжээг идэвхжүүлэх
- Өвлийн аялал жуучлалыг хөгжүүлэх
- Өвлийн спортыг хөгжүүлэх
- Шинээр хийгдэж буй хиймэл нуурыг ашиглалтад оруулах, нууран дээр хөвөх завиудыг худалдан авах
- хурим найрын үйл ажиллагааг гадаа хийдэг болох /том саравч худалдан авч /
- эко 00-ууд байрлуулах

2. Дээрхи төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг нэмэлт хувьцаа гаргах замаар болон өөр эх үүсвэрүүдээр санхүүжүүлэх боломжыг судлан арга хэмжээ авч

ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Амарбаатарт даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.АМАРБААТАР



“МОНГОЛ ШИЛТГЭЭН” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

“Банкны өр зээлтэй холбоотой асуудлыг” шийдвэрлэх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Монгол Шилтгээн” ХК-ийн 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянзүрх дүүргийн шүүхийн 2009 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 1184 дүгээр шийдвэрээр “Монгол шилтгээн” ХК-иас 2,375,781,693 /Хоёр тэрбум гурван зуун далан таван сая долоон зуун наян нэгэн мянга зургаан зуун ерэн гурав/ төгрөг гаргуулан Голомт банкинд олгохоор шийдвэрлэсний дагуу улсын бүртгэлийн 2204012457 дугаартай, БЗД-ийн Гачуурт тосгон дахь амралтын цогцолбор /1967 м.кв/ барилгыг 3031/0016 тоот эзэмших эрхийн гэрчилгээний дугаартай /36.000 м. кв/ газрыг битүүмжлэн, дуудлага худалдаагаар худалдан борлуулах шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгдэх болсонтой холбогдуулан доорх ажиллагаануудыг хийж гүйцэтгэхийг компанийн Төлөөлөн Удирдах зөвлөл /Ч. Амарбаатар/-д даалгасугай.

- Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүн С. Отгонбаатар нь компанийн хөрөнгийг барьцаалан зээлийг жуулчны баазын зориулалтаар авсан боловч зээлийн зориулалтыг өөрчлөн өөрийн хувиараа байгуулсан “Монгол фүүд” ХХК-ийн хүнсний хөргүүрийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг худалдан авах, хөргөх цехийн барилгын ажил, материал, тоног төхөөрөмжийн төлбөрт зориулж, зээлийн гэрээний үүргээ зөрчсөн, компанид хохирол

учруулсан, хувьдаа ашигласан үйлдлүүдийг эрүү болон иргэний хэргийн шүүхээр тогтоолгох нэхэмжлэл, гомдол гаргах

- Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйлийн 85.4-д заасны дагуу өөрийн буруугаас компанид хохирол учруулсан эрх бүхий албан тушаалтан буюу С. Отгонбаатараар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх хариуцлага хүлээлгэх
- “Монгол Фүүд” ХХК-тай холбоотой үл хөдлөх хөрөнгө, хувьцааны талаар судалж тогтоох
- Голомт банкны өрийг хувьцаагаар сольж компанийн хувьцаа эзэмшигч болгох замаар компанийн хөрөнгийг барьцаанаас чөлөөлүүлэх боломжийг судлах, хэлэлцээ хийх

2. Шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавьж, Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдэд танилцуулж, мэдээллээр хангах ажлыг хийж гүйцэтгэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга / А.Ариунсайн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.АМАРБААТАР